



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/83/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа	18
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БНСУлсын	Бүгд найрамдах Солонгос улсын
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,261,864.40	30,871,356.40
33	АВЛАГА	6,477,060.00	3,927,440.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	91,860.00	36,240.00
335	Бусад авлага	6,385,200.00	3,891,200.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,385,200.00	3,891,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37,784,804.40	26,943,916.40
351	Түүхий эд материал	33,004,814.40	22,721,806.40
35110	Тусгай зориулалттай материал	33,004,814.40	22,721,806.40
354	Хангамжийн материал	4,779,990.00	4,222,110.00
35410	Бичиг хэргийн материал	2,054,000.00	2,208,800.00
35420	Аж ахуйн материал	666,000.00	666,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,028,000.00	1,315,000.00
35440	Түлш, шатах тослох материал	31,990.00	32,310.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	918,707,914.39	951,589,731.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	918,707,914.39	951,589,731.31
392	Биет хөрөнгө	904,279,914.39	937,161,731.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	694,941,338.66	694,941,338.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-162,365,062.86	-205,855,323.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,639,521.00	158,639,521.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-122,200,978.77	-138,087,749.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	264,374,345.00	293,919,567.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-144,964,533.89	-101,294,706.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,426,836.62	73,312,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,897,197.22	-17,126,379.69
39209	Зам, гүүрийн байгууламж	768,255,100.00	768,255,100.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-753,356,850.00	-754,756,350.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	172,515,064.00	166,642,064.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-75,096,668.15	-69,436,599.18
39216	Дуусаагүй барилга, байгууламж	58,009,000.00	58,009,000.00
393	Биет бус хөрөнгө	14,428,000.00	14,428,000.00
39301	Програм хангамж	1,645,000.00	1,645,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-165,000.00	-165,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,948,000.00	12,948,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	962,969,778.79	982,461,087.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	962,969,778.79	982,461,087.71
51	Засгийн газрын хувь оролцоо	962,969,778.79	982,461,087.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	575,954,182.52	575,954,182.52
51101	Өмч: - төрийн	575,954,182.52	575,954,182.52
512	Хуримтлагдсан үр дүн	169,750,861.91	201,028,831.83
51210	Өмнөх үеийн үр дүн	169,750,861.91	181,537,522.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	19,491,308.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,264,734.36	205,478,073.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	962,969,778.79	982,461,087.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	490,522,278.90	519,887,945.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,370,081.00	114,764,503.00
120	Нийтлэг татварын бус орлого	85,370,081.00	114,764,503.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,370,081.00	114,764,503.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,370,081.00	114,764,503.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	405,152,197.90	405,123,442.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,141,097.90	43,169,242.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,141,097.90	43,169,242.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,011,100.00	361,954,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	374,011,100.00	361,954,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	507,362,167.21	498,990,386.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	507,362,167.21	498,990,386.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,912,389.21	481,911,970.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,924,543.00	219,688,273.00
210101	Үндсэн цалин	154,508,895.00	147,790,347.00
210102	Нэмэгдэл	41,141,048.00	38,328,616.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,274,600.00	33,569,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,881,264.00	28,708,962.30
210201	Тэтгэврийн даатгал	20,995,520.00	20,833,773.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,220,991.00	2,057,904.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,776,907.00	1,790,910.08
210204	Ажилгүйдлийн даатгал	583,219.00	354,233.38
210205	Эрүүл мэндийн даатгал	4,304,627.00	3,672,140.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,734,629.00	29,597,147.00
210301	Гэрэл, цахилгаан	2,672,177.00	3,117,469.00
210302	Түлш, халаалт	26,962,452.00	26,479,678.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,907,511.90	29,306,129.00
210401	Бичиг хэрэг	3,032,050.00	2,188,700.00
210402	Тээвэр, шатахуун	23,376,254.90	20,594,029.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,499,207.00	1,232,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,290,900.00
2105	Нормативт зардал	300,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,482,000.00	1,879,000.00
210604	Урсгал засвар	2,482,000.00	1,879,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,983,500.00	2,329,500.00
210702	Дотоод албан томилолт	2,983,500.00	2,329,500.00

**Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,398,548.00	1,253,497.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,310,548.00	303,497.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	162,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,300,393.31	169,149,462.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,844,454.90	69,891,526.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	104,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,455,938.41	99,153,936.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,449,778.00	17,078,415.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,736,142.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,736,142.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,713,636.00	17,078,415.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,713,636.00	17,078,415.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,839,888.31	20,897,558.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,406,250.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,406,250.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,406,250.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16,839,888.31	19,491,308.92

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	405,152,197.90	405,123,442.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	405,152,197.90	405,123,442.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,141,097.90	43,169,242.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,141,097.90	43,169,242.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,011,100.00	361,954,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,011,100.00	361,954,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	404,862,197.90	383,473,442.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,862,197.90	383,473,442.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,412,419.90	366,395,026.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,678,287.00	219,688,273.00
210101	Үндсэн цалин	154,508,895.00	147,790,347.00
210102	Нэмэгдэл	43,894,792.00	38,328,616.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,274,600.00	33,569,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,881,264.00	28,679,217.30
210201	Тэтгэврийн даатгал	20,995,520.00	20,612,520.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,220,991.00	2,074,556.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,776,907.00	1,786,598.16
210204	Ажилгүйдлийн даатгал	583,219.00	397,248.95
210205	Эрүүл мэндийн даатгал	4,304,627.00	3,808,293.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,734,629.00	29,597,147.00
210301	Гэрэл, цахилгаан	2,672,177.00	3,117,469.00
210302	Түлш, халаалт	26,962,452.00	26,479,678.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,329,013.00	16,204,800.00
210401	Бичиг хэрэг	3,599,950.00	2,520,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,099,600.00	10,452,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,629,463.00	1,232,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,499,547.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,499,547.00
2107	Томилолт, зочны зардал	2,973,500.00	2,329,500.00
210702	Дотоод албан томилолт	2,973,500.00	2,329,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,019,018.00	1,513,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,931,018.00	563,796.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	162,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,796,708.90	66,882,746.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,796,708.90	66,778,746.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	104,000.00

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,449,778.00	17,078,415.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,736,142.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,736,142.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,713,636.00	17,078,415.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,713,636.00	17,078,415.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>290,000.00</u>	<u>21,650,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	290,000.00	21,650,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	290,000.00	21,650,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	290,000.00	21,650,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	21,650,000.00
223001	Бусад хөрөнгө	290,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-290,000.00</u>	<u>-21,650,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	217,264,734.36	186,590,750.22	00.00	979,809,667.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-16,839,888.31	00.00	-16,839,888.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	217,264,734.36	169,750,861.91	00.00	962,969,778.79
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	217,264,734.36	169,750,861.91	00.00	962,969,778.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	11,786,661.00	00.00	11,786,661.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,954,182.52	217,264,734.36	181,537,522.91	00.00	974,756,439.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-11,786,661.00	00.00	00.00	-11,786,661.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	19,491,308.92	00.00	19,491,308.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	201,028,831.83	00.00	982,461,087.71

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,141,097.90	40,523,542.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,141,097.90	40,523,542.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,141,097.90	40,523,542.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	700,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,030,468.00	563,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,030,468.00	563,796.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,110,629.00	39,259,746.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,110,629.00	39,155,746.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,141,097.90	40,523,542.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,141,097.90	40,523,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,141,097.90	40,523,542.00

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	381,796,200.00	348,007,464.00	476,085,200.00	347,521,484.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,796,200.00	348,007,464.00	447,085,200.00	323,521,484.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341,099,500.00	328,271,322.00	447,085,200.00	323,521,484.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,471,500.00	234,678,287.00	235,471,500.00	219,688,273.00
210101	Үндсэн цалин	155,238,600.00	154,508,895.00	155,238,600.00	147,790,347.00
210102	Нэмэгдэл	43,958,300.00	43,894,792.00	43,958,300.00	38,328,616.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,274,600.00	36,274,600.00	36,274,600.00	33,569,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,788,700.00	29,881,264.00	31,788,700.00	28,679,217.30
210201	Тэтгэврийн даатгал	22,369,800.00	20,995,520.00	22,369,800.00	20,612,520.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,354,700.00	2,220,991.00	2,354,700.00	2,074,556.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,883,800.00	1,776,907.00	1,883,800.00	1,786,598.16
210204	Ажилгүйдлийн даатгал	470,900.00	583,219.00	470,900.00	397,248.95
210205	Эрүүл мэндийн даатгал	4,709,500.00	4,304,627.00	4,709,500.00	3,808,293.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,191,600.00	29,734,629.00	35,191,600.00	29,597,147.00
210301	Гэрэл, цахилгаан	3,391,000.00	2,672,177.00	3,391,000.00	3,117,469.00
210302	Түлш, халаалт	29,700,000.00	26,962,452.00	31,700,600.00	26,479,678.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	100,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,396,400.00	16,329,013.00	15,504,800.00	15,504,800.00
210401	Бичиг хэрэг	3,600,800.00	3,599,950.00	2,552,500.00	2,520,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,099,600.00	11,099,600.00	9,752,300.00	9,752,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,696,000.00	1,629,463.00	1,200,000.00	1,232,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	2,000,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	1,500,000.00	1,499,547.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	1,500,000.00	1,499,547.00
2107	Томилголт, зочны зардал	00.00	00.00	5,025,000.00	2,329,500.00
210702	Дотоод албан томилголт	5,025,000.00	2,973,500.00	5,025,000.00	2,329,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	1,088,000.00	950,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,617,200.00	1,900,550.00	00.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	300,000.00	162,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	50,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,521,100.00	10,686,079.00	121,515,600.00	25,273,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,521,100.00	10,686,079.00	121,515,600.00	25,273,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	0.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.00	290,000.00	29,000,000.00	24,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00	290,000.00	29,000,000.00	24,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	30,000,000.00	290,000.00	29,000,000.00	24,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	381,796,200.00	348,007,464.00	476,085,200.00	347,521,484.30
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	381,796,200.00	348,007,464.00	337,864,600.00	321,476,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	381,796,200.00	348,007,464.00	337,864,600.00	321,476,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00	138,220,600.00	26,045,484.30
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	138,220,600.00	26,045,484.30
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	23	23
620001	Удирдах ажилтан	06	06	06	06
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	10	10
620003	Үйлчлэх ажилтан	07	07	07	07

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, нийтийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай шударга хүргэж орон нутгаа хөгжүүлэх шууд ардчиллын зарчмыг баримталсан шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг хангуулах эрхэм зорилго үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажилласан, Төв аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Төв аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, засгийн бодлого шийдвэрийг анхан шатанд мөрдөж, хэрэгжүүлэх
- Сум, орон нутгаа хөгжүүлэх шууд ардчиллын зарчмыг баримталсан шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг хангуулах
- Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын "Дотоод хяналтын ажлын хэсэг"-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тайлант онд дотоод хяналтын ажлын хэсэг байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 7 ажлыг батлагдсан төлөвлөгөө удирдамжийн дагуу гүйцэтгэж, удирдлагад тайлагнасан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2.0 хувиар буюу 10,147.2 мянган төгрөгөөр тогтоож, ерөнхий материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,117.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 2.0 хувиар буюу 9,878.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 7,902.7 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон

материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 268.8 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “ Acolous ” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 361,954.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 114,764.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 43,169.2 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 519,887.9 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 361,954.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 43,169.2 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 405,123.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд иргэд аж ахуйн нэгж байгууллагаас хандив 5,900.0 мянган төгрөг, Төв Чандмань ДЭХГ-аас Засгийн газраас төлсөн усны үнэ 16,298,4 мянган төгрөг, Төв ХХААГ-аас оготно устгалын зардалд 4,000.0 мянган төгрөг, Төв аймгийн Засаг даргын нөөц сангаас ЕБС-н дээврийн засварт 15,903.0 мянган төгрөг, статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 667.8 мянган төгрөг, Төв аймгийн ИТХ-ын нэмэлт санхүүжилтээс ГХУССангийн хамтарсан багийн зардалд 400,0 мянган төгрөг, нийт 43,169.2 мянган төгрөг орлогоор төвлөрүүлсэн байна.

Зардал:

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 498,990.4 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 383,473.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141855001 тоот дансанд 361,954.2 мянган төгрөгийн орлого, 361,954.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн

100141855408 тоот дансанд 43,169.2 мянган төгрөгийн орлого, 43,169.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,215,754.2 мянган төгрөг, тайлант онд үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор 88,144.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг актлагдсан хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж шилжүүлэн авч, 2 байгууллагаас 21,650.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 66,993.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 28,718.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, бусад хөрөнгө 13,673.0 мянган төгрөг, нийт 109,384.3 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор шийдвэрлэн акталж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,216,164.3 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 37,784.8 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 63,616.0 мянган төгрөг, ОБГ болон иргэд ААН-с үнэ төлбөргүй шилжүүлэн авсан тусгай зориулалтын материал 2,972.5 мянган төгрөг, нийт 66,588.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 72,138.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, ашиглах боломжгүй болсон тусгай зориулалтын материалд бүртгэлтэй 5,290.9 мянган төгрөгийн хуулийн эмхэтгэл, туг далбаа, уриа лоозон гэх мэт материалыг акталж устган, бараа материалын эцсийн үлдэгдэл 26,943.9 мянган төгрөг байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант жилийн авлагын дансны эхний үлдэгдэл 6,477.1 мянган төгрөг, авлага нэмэгдсэн 636.2 мянган төгрөг, хасагдсан 3,150.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3,962.4 мянган төгрөг байна.

Өглөгийн дансны эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 435,617.9 мянган төгрөг, хасагдсан 435,617.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 17 байгууллагуудтай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 26,943.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 951,589.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0

Авлага	6,477.1	3,927.5	-2,549.6
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	37,784.8	26,943.9	-10,840.9
Үндсэн хөрөнгө	918,707.9	951,589.7	32,881.8
Нийт хөрөнгө	962,969.8	982,461.1	19,491.3
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	962,969.8	982,461.1	19,491.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	962,969.8	982,461.1	19,491.3

Авлагын дансны үлдэгдэл 3,927.5 мянган төгрөг болж, 636.2 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, 3,150.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулснаар, нийт 2,549.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 26,943.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 10,840.9 мянган төгрөгөөр буурсан нь ашиглах боломжгүй болсон тусгай зориулалтын материалд бүртгэлтэй 5,290.9 мянган төгрөгийн хуулийн эмхэтгэл, туг далбаа, уриа лоозон гэх мэт материалыг акталж устгасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 951,589.7 мянган төгрөг болж 32,881.8 мянган төгрөгөөр өсөхөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23,647.5 мянган төгрөгөөр 2 худаг, төсвийн хөрөнгөөр Сорос компьютер ХХК-с 15,200.0 мянган төгрөгөөр компьютер принтер, Эй ти чи ХХК-с 6,450.0 мянган төгрөгөөр цахим худгийн тоног төхөөрөмж худалдан авсан нь голлох нөлөөллийг үзүүлж байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 99,153.9 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 109,384.4 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 982,461.1 мянган төгрөг болж, 19,491.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 367,039.1 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөн, нийт урсгал зардалд 367,039.1 мянган төгрөг төлөвлөж, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний зардал төлөвлөөгүйгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,174.5 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал зардлын эх үүсвэрийг 337,864.6 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг 29,000.0 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 337,864.6 мянган

төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг 29,000.0 мянган төгрөгөөр, нийт 366,864.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор соёлын төвийн барилгын дээврийн засварт 60,000.0 мянган төгрөг, ковид-19 цар тахлын зардалд 30,000.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 12,907.4 мянган төгрөг, тэтгэмж урамшуулалд 6,313.2 мянган төгрөг, нийт 109,920.6 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлж, /138,220.6 мянган төгрөг болсон/ тодотгол хийгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 321,476.2 мянган төгрөгийн буюу 95.1 хувийн урсгал санхүүжилт авч, орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжих хөрөнгө оруулалт 40,478.2 мянган төгрөг авч зориулалтын дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 14,432.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 307,043.5 мянган төгрөг буюу 90.9 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын баяр наадмын зардлаас 1,500.0 мянган төгрөгөөр ЭМТ-д хүчилтөрөгчийн аппарат авч, ИТХ-ын тогтоолоор сумын ЭМТ-д балансаас балансад шилжүүлсэн.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор төсөвт урьд оны шилжих үлдэгдлээс тодотгол хийж соёлын төвийн барилгын дээврийн засварт 60,000.0 мянган төгрөг, ковид-19 цар тахлын зардалд 30,000.0 сая төгрөг, орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан тушаалтны тэтгэмжийн зардалд 6,313.2 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 12,907.4 мянган төгрөг, нийт 109,220.6 мянган төгрөгийг нэмж баталснаас тэтгэмжийн зардалд 6,313.2 мянган төгрөг, ковид-19 цар тахлын зардалд 10,165.0 мянган төгрөг, цахим худагт 8,800.0 мянган төгрөг, компьютер техник хэрэгсэлд 15,200.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд өөрийн байгууллагын автомашинаар 17504 км зам ажилд 6,745.6 мянган төгрөгийн шатахуун, бусдын автомашинаар 12070 км зам ажилд 13,848.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулснаар, нийт түлш шатах тослох материалын орлого 20,594.3 мянган төгрөг, зарцуулалт 20,594.0 мянган төгрөг байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 142 мэдээлэл байршуулж, 7 мэдээлэл хугацаа хоцроож 97.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 6 дугаар сарын 14-ний А/20 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулж байхыг Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 181,249.6 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 154,857.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 21,650.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,760.5 мянган төгрөгийн 3 зөрчилд акт тогтоож, 1,982.1 мянган төгрөгийн материаллаг бус 1 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийг ИТХ-ын тогтоолоор батлагдсан төлөвлөгөөтэй тулгахад тодотголын 114,131.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг хэлбэлзэлтэй тулгахад татан төвлөрүүлсэн 17,078.4 мянган төгрөгөөр тус тус тохируулаагүй алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 23,647.6 мянган төгрөгийн 2 худгийг орлого авч, данс бүртгэлд тусгаагүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Төв аймаг 2020 оны үйл ажиллагаагаараа “Шилдэг аймаг”-аар шалгарсан тул аймгийн ТАСЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 135 тоот албан бичгийг үндэслэн сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний Б/22 тоот захирамжаар Тамгын газрын дарга П.Оюунбилэгт үр дүнгийн мөнгөн урамшуулалд 1,259.3 мянган төгрөг олгож, зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 “Урамшуулал гэдэгт...нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

Төсвийг үр ашиггүй зарцуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн алданги, ажил олгогчоос төлөх шимтгэлд нийт 1,181.2 мянган төгрөгийг төсвөөс төлсөн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Оршин байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

Гэрээгээр нохой устгасан хөлстэй хамт гэрээнд заагдаагүй сумны үнэ 320.0 мянган төгрөгийг /анхан шатны е баримтгүй/ олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр 21,650.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Худалдан авалтыг е баримтаар баталгаажуулсан байдалд тулгалт хийхэд, 3 байгууллагатай холбоотой 1,982.1 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлээгүй” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрэн бүрдүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Угтаалцайд ам сумын Засаг даргын Тамгын газар	7	181,249.6	2	154,857.0	3	2,760.5	1	21,650.0	1	1,982.1